



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/159

Номгон

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын
сурлагын хоцрогдолд нөлөөлж буй хүчин
зүйлийг илрүүлэх судалгааны ажил
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 8/10 дугаар тогтоол, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах 6.1.3 дахь заалтын задаргааны 5 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Сурлагын хоцрогдолд нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх судалгааны ажил зохион байгуулах удирдамж", төсвийг хавсралтаар баталсугай.

2. Судалгааг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг) -т үүрэг болгосугай.

3. Судалгааны зардал болох 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний "Сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь), Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр) нарт даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310389

Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн захирамжийн хүрээлэлт



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН СУРЛАГЫН ХОЦРОГДОЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ИЛРҮҮЛЭХ СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАМЖ, ТӨСӨВ

Судалгаа хийх үндэслэл: Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 8/10 дугаар тогтоолоор “Ковидын дараах суралцагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх арилгах төлөвлөгөө”-г баталсан байдаг.

Энэ төлөвлөгөөний дагуу сургууль бүр өөрийн төлөвлөгөөг боловсруулан хоцрогдлыг нөхөх арилгах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа.

2022 оны 5-6 сард зохион байгуулагдсан гүйцэтгэлийн үнэлгээгээр тус аймгийн ерөнхий боловсролын 30 сургуулийн 922 багш хамрагдсан байна. 20 судлагдахуунаар авсан бичгийн шалгалтад 14,034 сурагч, асуулгад 13,079 эцэг эх, 8,066 сурагч, захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, заах аргын нэгдлийн ахлагч, багш нар хамрагдсан байна.

Ерөнхий үнэлгээгээр аймгийн дундаж улсын дунджаас 1,7%, орон нутгийн дунджаас 0,7% доогуур, бичгийн шалгалтын үнэлгээ улсын дунджаас 6,2%, орон нутгийн дунджаас 3,6% доогуур үзүүлэлттэй шалгагдсан байна. Шалгуур тус бүрийн үнэлгээгээр хамгийн доогуур үнэлгээг “сурах үйл ажиллагаа”-55,4 хувьтай гарсан ба үүнээс “бичгийн шалгалт”, “хэрэглэгдэхүүний ашиглалт” гэсэн үзүүлэлтүүд бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Иймд “Суралцагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх арилгах төлөвлөгөө”-ний явцын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, ер нь суралцагчид амжилттай суралцахад ямар хүчин зүйл сөрөг болон эерэг нөлөөтэй байгаа, цаашид багш нарт энэ талаар зөвлөмж зөвлөгөө өгөх зайлшгүй шаардлага байна.

Судалгааны зорилго: Цар тахлын үеийн хөл хорионы улмаас үүссэн суралцагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх арилгах төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад үнэлгээ хийж сурлагын хоцрогдолд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж гаргаж ирэх

Судалгааны зорилт:

1.Сургуулийн сургалт, үйл ажиллагааны хөтөлбөр, түүний хэрэгжилттэй танилцах

2.Судлагдахуун бүрээр суралцагчдын сурлагын түвшинг тогтоох

3.Эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжлэг авах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж байгааг тодруулах

4.Багш нарын хичээл, сургалтын үйл ажиллагааг хэрхэн явуулж байгаатай танилцах

5.Сурагчдын бие даан сурах үйл ажиллагаанд хэрхэн суралцаж байгаатай танилцах

6.Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, түүний хүрэлцээ хангамж, сурагчдын амьдрах орчныг судлах

Судалгааны аргачлал: Судалгаанд шаардлагатай мэдээллийг дараах аргаар цуглуулж авна. Үүнд:

Тоон судалгаа

- Статистик үзүүлэлтүүд
- Асуумж судалгаа
- Туршилт анализ

Чанарын судалгаа

- Ажиглалт
- Бүлгийн ба ганцаарчилсан ярилцлага
- Баримт бичгийн судалгаа
- Кейс судалгаа

№	Судалгааны явцад хийх үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	Сургуулийн сургалт, үйл ажиллагааны хөтөлбөр, түүний хэрэгжилттэй танилцах	Сургалтын менежер, мэргэжлийн хөгжлийн бүлгийн ахлагчид	4-5 сард	М.Мөнхбат О.Будхүү
2	Сургуулийн захирал, удирдах ажилтантай ярилцлага хийх	Захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан	4-5 сард	С.Гандалай
3	Багш нартай ярилцах, судалгаа авах	Түүврээр бага, дундын 15-20 багш	4-5 сард	Г.Одонтунгалаг
4	Сурагчидтай ярилцах	Түүврээр 30-40 сурагч хамруулах	4-5 сард	Б.Нямдулам
5	Сурагчдаас түвшин тогтоох шалгалт авах	Судлагдахуун бүрээр	2-6 сард	Л.Оюунбилэг Мэргэжилтнүүд
6	Хичээлд ажиглалт хийх	Судлагдахуун бүрээр	4-5 сард	Мэргэжилтнүүд
7	Хичээлийн хэлэлцүүлэг, зөвлөгөө	Сургалтын менежер, багш нар	4-5 сард	Мэргэжилтнүүд
8	Суралцагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх арилгах чиглэлээр эцэг, эхээс судалгаа авах	Түүврээр 30-40 эцэг эх хамруулах	4-5 сард	Д.Цэцэнхүү

9	Сайн туршлагыг бүртгэх	Мэргэжлийн хөгжлийн бүлгийн ахлагчид	4-5 сард	М.Угтахбаяр
---	------------------------	--------------------------------------	----------	-------------

Судалгаа явуулах: Судалгааг аймгийн хэмжээний төрийн болон төрийн бус өмчийн 32 сургууль дээр 2023 оны 01дүгээр сараас 10 сар хүртэлх хугацаанд явуулна.

СУРЛАГЫН ХОЦРОГДОЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ИЛРҮҮЛЭХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТӨСӨВ

№	Үйл ажиллагаа	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Шалгалтын сэдэв, даалгавар боловсруулах, хувилах, нэгтгэх	12800	180	2.304.000
2	Асуумж, судалгааны асуулга боловсруулах, хувилж олшруулах, нэгтгэх	4500	180	810.000
3	Замын зардал (бензин, масло)	350 л, 1580 км	2530	885.500
	Бүгд			4.000.000

Судалгааны үр дүнг боловсруулж дүн шинжилгээ хийх: Асуудлыг нарийвчлан тодорхойлж шийдвэрлэх арга замыг боловсруулах зорилгоор чанарын болон тоон судалгааны арга зүйгээр судалгааг хийнэ. Судалж буй зүйлийн тоон болон чанарын өөрчлөлтийн зүй тогтолд нөлөөлөх гол хүчин зүйл, харилцаа хамаарал, нөлөөллийг тогтооно.

Судалгааны үр дүнгээр дүгнэлт, зөвлөмж гаргаж сургууль, багш нарт хүргэнэ.